

НИЙГМИЙН ХӨГЖИЛ БА СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ СЭТГЭЛГЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛ

С.Батхуяг, Sc.D, профессор, БоСС

Оршил

Бүх төрлийн шинжлэх ухаан, түүний дотор сурган хүмүүжүүлэх ухаан нь хүний нийгмийн хөгжлийн үе шатанд нийгмийн бодит хэрэгцээнд уялдан бий болж төлөвшин хөгжиж ирсэн түүхтэй. Эдүгээ ч энэ зүй тогтол үйлчилсээр байгааг сурган хүмүүжүүлэх ухааны хөгжлийн өнөөгийн байдлаас олж харж болно. Тухайлбал, бүх шатны сургуулийн сургалт хүмүүжлийн ажлын чанар, үр өгөөж нь нийгмийн өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй, суралцагчид болоод багш нарын хооронд үзэл бодол, харьцаа хандлагын зөрчил, урьд өмнөхөөс илүү хурц байдалтай илрэх болж сурах, сургах үйлдээ сэтгэл ханамжгүй байх нь нилээд түгээмэл шинжтэй байгаа нь үүний нотолгоо юм. Энэ нь нийгмийн эрс шинэчлэлтэй уялдан суралцагчдын хэрэгцээ, сонирхолд гарч байгаа өөрчлөлттэй тэдэнд үйлчилж байгаа багш, сурган хүмүүжүүлэгчдийн хандаж буй хандлага, үзүүлж буй үйлчилгээний агуулга, арга хэлбэр зохицохгүй байгаагийн илрэл юм.

Боловсролын үйлчилгээний агуулга, арга хэлбэр нь эдгээрийг боловсруулан хэрэгжүүлэх эзэн болох багш, сурган хүмүүжүүлэгчдийн итгэл үнэмшилтэй шууд холбоотой бөгөөд энэ нь тэдний сурган хүмүүжүүлэх сэтгэлгээний хандлага, байр сууриар тодорхойлогддог.

Сурган хүмүүжүүлэх сэтгэлгээний хандлага нь сурган хүмүүжүүлэх ухааны үндсэн ухагдахуунуудыг ямар түвшинд яаж тодорхойлж, томьёолж байгаагаас хамаардаг.

Хүний нийгмийн хөгжлийг дагаж сурган хүмүүжүүлэх сэтгэлгээнд байнгын хувьсал өөрчлөлт орж тэр нь сурган хүмүүжүүлэх ухааны үндсэн ухагдахуунууд (категориуд)-ын тодорхойлолтод тусгалаа олж байсан ба тэдгээрийг ямар түвшинд юу гэж ойлгож байгаагаас багш, сурган хүмүүжүүлэгчдийн өөрсдийнх нь сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа хандах хандлага нь хамаарч байдаг.

1990-ээд он хүртэл манай сурган хүмүүжүүлэгчид социалист сурган хүмүүжүүлэх ухааны үзэл баримтлалыг өөрсдийн үйл ажиллагаанд мөрдөж ирсэн.

Гэтэл Монгол орон өмнөх нийгмээс эрс өөр чиг баримжаатай хөгжлийн замыг сонгож авсантай уялдан өсвөр хойч үеэ сурган хүмүүжүүлэх

хандлага, үзэл баримтлалд ихээхэн өөрчлөлт орсон хэдий ч энэ нь сургууль, багш нарын үйл ажиллагаанд тэр бүр бодитой хэрэгжиж чадахгүй байгаа билээ.

Сурган хүмүүжүүлэх онолын болоод практик сэтгэлгээнд өөрчлөлт орж шинэчлэгдэх үйл явц ид явж байна. Чухам энэ үед сурган хүмүүжүүлэх ухааны үндсэн ухагдахуунуудыг нийгмийн шинэ орчин нөхцөлд нийцүүлэн дахин авч үзэж шинэчлэн томьёолох шаардлага юун түрүүнд тавигдана.

Сүүлийн үед сурган хүмүүжүүлэх ухааны үндсэн категориуд гэж нэрлэгддэг "бие хүн", "хүмүүжил", "боловсрол", "сургалт", "сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа" г.м гол гол ухагдахуунуудыг судлаачид, эрдэмтэд, багш, сурган хүмүүжүүлэгчид өөр өөрөөр ойлгож бичиж, ярьж, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийг оролдож байна. Энэ нь нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан иргэн-бие хүн төлөвшүүлэхэд нөлөөлж байгаагаас гадна судлаачдын судалгаа бүтээлд ч тодорхой хэмжээгээр тусгалаа олж байна.

Шинжлэх ухааны ухагдахууны тодорхойгүй, нэгэн утгатай биш байдал болон нэр томьёогүй болон эсхүл тэдгээрийг хольж хутгах нь судлаачдыг ажлын найдвартай хэрэгсэлгүй, гар мухардмал байдал оруулахаас (В.Е.Тмурман. 1985, с:42) гадна сургууль, багш нарын үйл ажиллагааг ч чиг баримжаа муутай болгодог.

Тухайлбал ухагдахуун тодорхойгүй бүрхэг байх нь бодит байдлыг янз бүрээр заримдаа бүр дураараа тайлбарлах нөхцөлийг бий болгож эцсийн эцэст шинжлэх ухааны хөгжлийг саатуулахад хүргэх аюултай болохыг профессор В.Е.Тмурман онцгойлон тэмдэглэсэн байдаг.

Өнөөдөр манай орны сурган хүмүүжүүлэх ухааны онол, практикийн хувьд чухам ийм нөхцөл байдал хэдийнээ бий болжээ.

Социалист нийгмийн үеийн сурган хүмүүжүүлэх ухааны үзэл баримтлал нь хүмүүнлэг ардчилсан нийгмийн үеийнхээс зарчмын ялгаатай. Гэтэл энэхүү ялгааг тодорхой ухаарч ойлгоогүйн улмаас хүмүүнлэг сурган хүмүүжүүлэх ухааны үндсэн категориудын агуулга, мөн чанарыг шинжлэн ухаарч тодорхойлж (томьёолж) чадахгүй байгаатай уялдан дээрх нөхцөл байдал үүссэн гэж

үзэх үндэстэй.

Хүмүүнлэг сурган хүмүүжүүлэх ухааны, социалист сурган хүмүүжүүлэх ухаанаас ялгагдах гол ялгаа нь хүнийг өөрийг нь өөрийнхөө хөгжин төлөвших үйлийн эзэн (субъект) байх ёстой гэж үздэгт оршино. Чухам үүнд тулгуурлаж сурган хүмүүжүүлэх ухааны үндсэн категориудын агуулгыг тодорхойлох нь сурган хүмүүжүүлэх сэтгэлгээний шинэчлэлийн үр дүн (илрэл) болно.

Гэтэл өнөөдөр энэ талд төдийлөн анхаарахгүй хүн хүн өөрийнхөөрөө ярьж, бичиж байгаа нь манай орны сурган хүмүүжүүлэх ухаанд төдийгүй сургууль, боловсролын үйл ажиллагаанд ч сөргөөр нөлөөлж, шинэчлэл удааширч, цаг хугацаа алдагдаж байгааг бид анхаарахгүй байж болохгүй.

Ийм учраас энд бид сурган хүмүүжүүлэх ухааны гол тулгуур гурван ухагдахууны талаарх өөрсдийн үзэл бодлыг та бүхний анхааралд толилуулахыг зорив.

1. "Бие хүн" (личность, personality)

Энэ нь философи, сэтгэл судлал, нийгэм судлал, сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг хүн судлалтай холбоотой олон шинжлэх ухааны үндсэн категори болдог бөгөөд тухай тухайн шинжлэх ухаандаа өвөрмөд байдлаар тодорхойлогдсон тодорхойлолттой байдаг.

Бас тухайн нэг шинжлэх ухааны хувьд ч эрдэмтэн, судлаач бүхэн өөр өөрийн ойлголтоор тодорхойлж томъёолдог нь сурган хүмүүжүүлэх шинжлэх ухаанд ч ажиглагддаг. Жишээ нь:

Бие хүн (Личность) улс нийгэмд тодорхой байр суурь эзэлж буй ухамсартай хувь хүн (индивид) юм. (Б.Борнар. 1981.19-р тал)

Личность - бие хүн - Өөрийгөө бусдаас ялган, "Би" гэдгээ ойлгож, хүрээлэн байгаа орчин, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох болсон сэтгэцийн хөгжлийн тодорхой түвшинд хүрсэн хувь хүн. (Д.Ванчигсүрэн нар. 1994. 48-р тал)

Бие хүн бол нийгэмшсэн хүн буюу нийгэмд өөрийн байр суурь эзэлсэн, өөрийн үзэл бодолтой, нийгэмд бие даан ажиллах, амьдрах газар бүхий хүн юм. (Ш.Ичинхорлоо нар. 1999. 7-р тал)

Дээрх тодорхойлолтууд "бие хүн" гэдгийн дор "хувь хүн", "хүн"-ийг ойлгож, түүгээр "бие хүн"-ийг тодорхойлж байгаа нь илэрхий байна.

Кантынхаар хүн нь амьтнаас өөрийг нь ялгаруулах, өөрийгөө зан суртахууны хуулийн дагуу захирах өөрийн ухамсар өөрөө бие хүн болдог. (Психологический словарь. 1983.179-р тал)

Личность-это целостная система, которая выполняет определенные функций и возникает у человека, чтобы обслуживать эти функций. (Л.С.Выготский)

Эндээс харвал "бие хүн" гэдэг нь хүнийг өөрийг нь бус харин түүнд бүрэлдэн төлөвшиж буй чанар, чадварын тогтолцоотой холбоотой ухагдахуун (ойлголт) байж болох талтай байна.

Тэгээд ч бид, "бие" хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх "бие хүний шинж", "мэргэжилтэн-бие хүн" гэх мэтийн хэллэг, нэр томъёог ашигладаг.

Түүнчлэн монголчууд "хүн" гэдэг ухагдахуунтай холбоотой "бодгаль хүн", "гарвал шинж" гэсэн ухагдахуунуудыг бас түгээмэл хэрэглэдэг.

Энэ бүгдийг уялдуулан авч үзвэл "хүн" нь дээд зэргийн хөгжилтэй уураг тархи бүхий хоёр хөл дээрээ явж, хоёр гараараа ажиллах чадвартай нэгэн төрөл амьтан бөгөөд тэр нь эхийн хэвлийгээс "бодгаль хүн" болж төрөх ба түүнд түүний "гарвал шинж" агуулагдаж байна. Энэ нь чухамдаа "байгалийн бүтээгдэхүүн" болно.

Тэрхүү "бодгаль хүн" нь байгалийн болон нийгмийн орчинд өсч торниж, хөгжих бөгөөд үүний үр дүнд түүний "гарвал шинж" дээр олон шинэ шинэ шинж, ур чадвар төлөвшин бүрддэг. Энэхүү бүрэлдэн төлөвшсөн шинжүүдийн цогц нэгдлийг "бие хүн" гэдэг ухагдахууны агуулгад багтаан ойлговол зохилтой мэт.

Ингэвэл: Бие хүн гэдэг нь бодгаль хүнд байгаль, нийгмийн хүчин зүйлсийн нөлөөгөөр бүрэлдэн төлөвшсөн чанаруудын нэгдэл болно.

Ингэж бие хүн төлөвших үйл явц нь тухайн бодгаль хүний өөрийнх нь үйл ажиллагаатай шууд холбоотой явдаг,

Энэхүү бодгаль хүний үйл ажиллагааны шинжээс бие хүний төлөвшилтийн чанар хамаарахаас гадна бие хүн шинж төлөвшихийн хэрээр бодгаль хүн нь өөрийн хөгжил, төлөвшилтийг жолоодох чадвартай болно. Ингэснээр өөрөө өөрийнхөө эзэн нь өөрөөр хэлбэл биеэ мэддэг (хүн) болно.

2. Хүмүүжил (Воспитание).

Энэ нь сурган хүмүүжүүлэх ухааны хамгийн гол тулгуур ухагдахуун. Гэтэл үүнийг эдүгээ хүртэл нийгмийн янз бүрийн тогтолцооны үед өөр өөрөөр ойлгохоос гадна, түүхэн нэг тодорхой үедээ харилцан адилгүй тодорхойлж ирсэн байна. Жишээ нь:

- Хүмүүжил бол хувь хүн цогцлон төлөвших ба нийгэмших процесс, түүнийг хөтлөх үйл ажиллагаа, нийгмийн хэрэгцээ шаардлагад зохицуулан ухамсар ухаан суулгаж төрх байдлыг тогтоон цэгцлэх идэвхтэй процесс. Өөрөөр хэлбэл бие хүн болж төлөвших үйл ажиллагаа арга замыг тодорхой зорилго, төлөвлөгөөтэй, эрэмбэ, дараалалтай

удирдан хөтлөх, улс орондоо хэрэгтэй, үнэ цэнэтэй иргэдийг бүх талаар бэлтгэж орчин үеийн хүний бүхэл бүтэн ба тусгай шинж чанарыг бүрэлдүүлэх үйл явц юм. (Б.Борнар, 1981. 39-р тал)

- Хүмүүжил бол хүүхдэд хүний эрхэм нандин чанаруудыг төлөвшүүлэх, нийгмийн үнэт зүйлүүдийг ойлгуулах, хүмүүстэй зөв харьцах, биеэ боловсон зөв авч явах, бие дааж амьдрах арга ухаан олгох өргөн агуулгатай үйл явц юм. (Ш.Ичинхорлоо нар, 1999. 7-р тал)
- В широком педагогическом смысле воспитание-это специально организованное, целенаправленное и управляемое воздействие коллектива, воспитателей с целью формирования у него заданных качества. (Подласый, 19... с.24)

Дээрх тодорхойлолтуудаас үзэхэд "хүмүүжил" гэдгийг хүнд гаднаас тодорхой зорилго чиглэлтэй нөлөөлөх замаар явах "үйл явц" гэж ойлгодог байдал харагдаж байна.

Ер нь "хүнийг хүмүүжүүлэх" гэсэн хэллэг нь ч үнэхээр "хүнийг (хөндлөнгөөс) хүчээр хүмүүжүүлэх" гэсэн утгыг илэрхийлдэг ба олон хүн түүний дотор багш, сурган хүмүүжүүлэгчид ч ингэж ойлгож үйл ажиллагаандаа ханддаг байдал ажиглагддаг. Энэ бол социалист сурган хүмүүжүүлэх ухааны "иргэнийг нийгмийн хэрэгцээ шаардлагад зохицуулан төлөвшүүлэх" гэсэн үзэл баримтлалын тусгал л даа.

Гэтэл "хүмүүжил" гэдэг үгийг "хүмүүншил" гэсэн утгаар ойлгож болох талтай. Зарим судлаачид түүний дотор доктор, профессор Ш.Шагдар, Б.Жадамба (2006. 162-р тал) нар "хүмүүнжих" гэсэн утгаар тайлбарласан нь бий. Гэхдээ "хүмүүнжих" гэдгийг "малжих" гэдэгтэй зүйрлэж ухвал "хүмүүн олонтой болох" гэсэн санааг илэрхийлж болох талтай тул миний бие "хүмүүнших" гэвэл "хүмүүн шинжтэй болох" гэж буух боломжтой юмуу гэж санадаг хэрэг.

Хэрвээ "хүмүүжил"-ийг "хүмүүншил" гэж ойлговол энэ нь заавал гаднын хүч нөлөө үйлчлэлээр явах үйл явц биш "хүмүүнших" үйлийн эзэн-(бодгаль) хүн өөрөө голлох үүрэгтэй байж таарна.

Чухам ингэж үзсэний үүднээс өчүүхэн би бээр "хүнийг хүн хүмүүжүүлэхгүй, хүн өөрөө өөрийгөө л хүмүүншүүлэх учиртай" гэж ойлгодог ба бусдыг ч ингэж ойлгоосой гэж хүсдэг.

Хүмүүнлэг сурган хүмүүжүүлэх ухааны социалист сурган хүмүүжүүлэх ухаанаас ялгагдах нэг гол ялгаа нь хүнийг өөрийг нь сурган

хүмүүжүүлэх үйл явцын төвд байлгаж түүнд өөрөө өөрийнхөө хүсэл сонирхол, авъяас чадвар, хэрэгцээнд зохицуулан өөрөө өөрийгөө өөрчлөн хөгжүүлэх боломж олгохыг чухалчилдагт оршдог. Ийм нөхцөлд "хүнийг хүмүүжүүлэх" тухай биш, "хүний хүмүүнших" орчин нөхцөлийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх тухай л ярих боломжтой.

Хүмүүнших нь бодгаль хүнд хүмүүний шинж, зан төлөв, ёс суртахуун, итгэл үнэмшил төлөвших үйл явц бөгөөд хүмүүншил нь түүний үр дүн юм. Ийм учраас "хүмүүжил"-ийг хүний "хүмүүнших үйл явцын үр дүн" гэж тодорхойлбол зохилтой.

Сургууль, багш нарын сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаа нь түүнд хамрагдагсдын хүмүүнших аятай таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ. Сурган хүмүүжүүлэх ажлын үр дүн хүмүүншил нь гагцхүү суралцагчдын өөрсдийнх нь идэвх чармайлтаас хамаарна.

Өнөөдөр ингэж ойлгоогүйгээс хүүхдийг зөвхөн "хүмүүжлийн ажлаар хүмүүжүүлэх" ёстой гэж үзэж хичээлийн хүмүүншүүлэх нөлөөг дутуу үнэлснээс болж сургалтыг зөвхөн "сургах" л үүрэгтэй мэт хандсаар байгаа билээ.

3. Боловсрол (Образование, Education)

Энэ нь хэн бүхэнд хамгийн танил үгнүүдийн нэг хэдий ч чухам "Боловсрол гэж юу вэ?" гээд тулгаад асуухад багш хүн ч гэсэн тэр бүр бэлэн тодорхойлолт томъёолоод хэлчихэж болохгүй байх нь цөөнгүй.

Үүний учир шалтгаан нь энэ талаар тухайн хүнд бүтээгдсэн мэдлэг, итгэл үнэмшил тодорхой биш байгаагийн илрэл.

Хэвлэгдсэн бүтээлүүд дээрээс "боловсрол" гэдэг ухагдахууны тодорхойлолтуудыг харьцуулан үзэхэд ч мөн л өөр өөр утгатай байх нь ажиглагдана. Жишээ нь:

- Боловсрол нь ... мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх бие хүний шинжийг төлөвшүүлэх үйл ажиллагаа (Ц.Бүжидмаа. 1995. 5-р тал)
- Боловсрол гэдэг нь... шинэ мэдлэг, үзэл санаа, дадал, чадвар, хандлагыг эзэмшүүлж, ... хөгжүүлэн төлөвшүүлэх тодорхой зорилго, чиглэл, төлөвлөгөөтэй зохион байгуулалт бүхий үйл явц. (Н.Наранчимэг. 2002. 5-р тал)
- Образование-это общественно организуемый и нормируемый процесс постоянной передачи предшествующими поколениями последующим социально значимого опыта.. (Педагогика. 1998. с.209)

Дээрх тодорхойлолтуудад "боловсрол"-ыг нийгмийн үзэгдэл болох талаас нь авч үзэж тодорхойлсон ба түүний жинхэнэ мөн чанар, үндсэн субъектыг төдийлөн тодорхой гаргаж өгөөгүй ерөнхий байгаа нь харагдаж байна.

Түүнчлэн боловсролыг системтэй мэдлэг чадвар эзэмших (эзэмшүүлэх) үйл явц, түүний үр дүн гэсэн утгаар тодорхойлсон байх нь бий. Тухайлбал Д.Ванчигсүрэн, Б.Энхтүвшин (1994) нар "Боловсрол судлалын ухагдахууны товч тайлбар толь"-доо "Боловсрол нь зохион байгуулалттай сургалтын явцад тодорхой агуулга бүхий системтэй мэдлэг, чадвар дадлыг эзэмших үйл явц, үр дүн" (Д.Ванчигсүрэн. 1994. 61-р тал) гэснээс гадна "Педагогическая энциклопедия"-д "Образование-процесс и результат усвоения систематизированных знаний, умений и навыков" (Педагогическая энциклопедия. 1966. с.141) гэж тодорхойлсон байдаг.

Энд боловсролыг хүний мэдлэг, чадвар, дадал эзэмших үйл, эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлаар тодорхойлсон ба олон ч хүн ингэж ойлгодог талтай.

Гэтэл боловсролын мөн чанар болон хүний боловсрохын утга учрыг гүнзгий бодож үзвэл боловсролыг зөвхөн эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлаар тодорхойлох нь хангалтгүй юм.

Боловсролын (боловсролтой) хүн гэдэг нь үнэндээ их ном үзсэн, олон сургууль төгссөн хүн бус ажиллаж амьдрахын арга ухаантай болсон хүн болох нь бодит амьдралаас тодорхой харагддаг. Иймд "боловсрол" гэдэг ухагдахууныг арай өөрөөр тодорхойлбол зохилтой. Үүнд:

Боловсрол нь өргөн утгаараа нийтийн үйлчилгээний салбар юм. Тодруулбал, иргэний сурч, боловсрох эрхээ эдлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх зорилго чиглэлтэй үйлчилгээ.

Боловсролыг явцуу утгаар нь авч үзвэл хүний өөрийгөө боловсруулж хөгжүүлэх үйл ажиллагааных нь үр дүн болно. Тэгэхдээ бүр түүний ухамсартай, тодорхой зорилго чиглэлтэй үйл ажиллагааны үр дүн юм. Иймд боловсрох үйлийн эзэн нь хүн өөрөө байх тул хүнийг (өөр) хүн боловсруулах (боловсрол эзэмшүүлэх)-гүй, хүн өөрөө л өөрийгөө боловсруулах учиртай. (С.Батхуяг нар. 2005. 5-р тал) Гэтэл өнөөдөр бид "боловсрол олгоно", "боловсрол эзэмшүүлнэ" гэж ярьдаг маань боловсрохуйн утга учрыг дутуу ухаарсны илрэл юм.

Сүүлийн үед "мода" болж байгаа "мэдлэг бүтээлгэх" гэдэг маань чухам сурч боловсрохуйн үйлийг хөтөлж жолоодохын утгыг илэрхийлсэн хэллэг болохыг ойлгож "мода" болгож ярих биш

"зарчим" болгож хэрэгжүүлэх шаардлагатай болж байна.

Энэчлэн сурган хүмүүжүүлэх ухааны бараг л бүх ухагдахууны тодорхойлолтыг эргэн харж, энэ цаг үеийнхээ бодит нөхцөл байдал, шинжлэх ухааны хөгжлийн өнөөгийн түвшинд зохицуулан дахин оновчтой, тодорхой болгохгүй бол хий хоосон номчирхол, "онолдол"-оос хэтрэлгүйгээр цаг хугацааг алдаж сургууль, багш нарын сэтгэлгээний шинэчлэл удаашрах нь тодорхой.

Иймд профессор В.Е.Тмурманы тэмдэглэсэнчлэн сурган хүмүүжүүлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг нарийвчлан тодорхойлж томьёолох нь түүний хөгжлийн тодорхой нэг хандлага болж байна. (Методологические проблемы развития педагогической науки. 1985. 42-р тал)

Энэ бол нэр томьёогоор хөөцөлдөж буй хэрэг биш сурган хүмүүжүүлэх онолын болон практик сэтгэлгээний шинэчлэлийн асуудал юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. С.Батхуяг, С., Энхжаргал, Б., Ононтуул, Б. Нийгмийн өөрчлөлт, сурган хүмүүжүүлэх сэтгэлгээний шинэчлэл. "Боловсролын шинэчлэл-хамтын ажиллагаа" олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Улаанбаатар хот. 2006 он 48-52-р тал
2. Бор, Б., Оюун, Ц., Чүлтэмжамц, Ш. Сурган хүмүүжүүлэх зүй. ред. Д.Санжжав. Улаанбаатар. 1981
3. Бүжидмаа, Ц. Боловсролын философийн зарим асуудал. Улаанбаатар. 1995
4. Ванчигсүрэн, Д., Энхтүвшин, Б. Краткий толковый словарь эдукологических понятий. Боловсрол судлалын ухагдахууны товч тайлбар толь. ред. Н.Бэгз, Улаанбаатар. 1994
5. Жадамба, Б., Жонни Балтзерсен. Сонирхлын бүлгүүдийн ЗАН түшиглэсэн "хүмүүний хөгжлийн чанар"-ыг сайжруулах хамтын ажиллагаа. "Мэдээлэл 2006" Улаанбаатар. 2006 157-164
6. Ичинхорлоо, Ш., Цэнд, С. Сурган хүмүүжүүлэх зүйн ерөнхий үндэс. Ред. С.Нэргүй. Улаанбаатар. 1999
7. Методологические основы развития педагогической науки. Под ред. П.Р.Атутова, М.Н.Скаткина, Я.С.Турбовского. -М., Педагогика", 1985
8. Наранчимэг, Н. Боловсролын шинэчлэл, сургалтын технологийн удирдлага. Улаанбаатар. 2002
9. Педагогика. Под ред. П.И.Пидкасистого. Педагогическое общество. России. -М., 1998

Монголын боловсрол судлалын 15 жил:
Туршлага ба сургамж бүтээлийн эмхэтгэл.